

ЗАСАГ ДАРГА **БАТЛАВ** Б.БАТСАЙХАН

**“ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2024.09.24

1. Байршил: Завхан аймгийн Баянхайрхан сумын нутаг дэвсгэрт гүн өрмийн худаг гаргана.
2. Ажлын тодорхойлолт: Ундны усны хангамжид зориулж гүн өрмийн худаг шинээр гаргана.
 - 2.1 Худгийг шинээр гаргахаас өмнөх ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.
 - 2.2 Худгийн цооног ерөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага 6088:2010 стандартын дагуу ажлын иж бүрдэл цооног ерөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт, туршилтийн ажлыг явуулж, худгийн усны шахуурга сонгох, цахилгаан үүсгүүрийг сонгон худгийн барилга барих ус хадгалах сав, насос бетон суурь холбох хэрэгсэл тоног төхөөрөмж суурилуулах ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
 - 2.3 Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам” - ыг мөрдөнө. Үүнд:
 - Ажлын иж бүрдэлд цооног ерөмдөх, бэхэлгээ, суултын яндан, шүүр суурилуулах, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр суурилуулах, ус түгээх байрны ажлыг багтаана.
 - Шинээр худаг гаргах, ерөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ. Ус багатай бол ерөмдөх шаардлагагүй, дахин хайгуул хийнэ.
 - Худгийн цооног ерөмдлөгийн ажлын талаархи мэдээллийг ерөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ. Ерөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.
 - Худгийн барилга 1 Хэмжээ /дотор талдаа/: 4x3м, ханын өндөр шалнаас дээш 2м] Материал: тоосго, блок, төмөр модон байж болно.1 Ханын зузаан: 38см-ээс багагүй 1 Худгийн дээр 30x30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ.
 - Худгийн цонх нь 40x50 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай

байна. /Цонхны байрлал нь Ус түгээх цооногын чанх харалдаа байрлана.

- Усан сан нь босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м³ -ээс багагүй багтаамжтай, ган усан сан нь дээгүүрээ модон тагтай. Цэвэрлэгээ үйлчилгээг хийж доогуураа усаа шавхарах боломжтой.
- Усны шахуурга болон цахилгаан үүсгүүрийг ашиглалтанд орсноос эхлэн 1 жилээс доошгүй баталгаат хугацаа өгнө. 1309001 гэрчилгээтэй байна. Албан ёсны үйлдвэрлэгчээс борлуулах эрхтэй компаниас худалдан авна. Баталгаат хугацаанд техникийн засвар үйлчилгээг бараа нийлүүлэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.
- Усны шахуурга нь усны орчны хасах 45 хэмээс нэмэх 35 хэм | Нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон үйлдвэрлэгч компанийн хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар /Монгол хэл дээр/ бэлтгэсэн байна.
- Усны шахуурга болон цахилгаан үүсгүүрийн түргэн элэгддэг эд ангийн сэлбэг тус бүр 2 ширхэгийг дагалдуулна.
- Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно. Худгийн усны тоолуур нь автомат байх шаардлагатай. Өвлийн хүйтэнд ард түмний ундны усны хэрэгцээг хангах тул мөстөлт үүсэхгүйгээр хэрэгцээг хангах боломжийг бий болгох. Мал услах талбай шаардлагагүй.
- Худгийн техникийн паспортыг хөтөлж, аймгийн БОАЖГазраар баталгаажуулан, сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгнө.
- “Гүн өрмийн худаг, уст цэгийг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай Завхан аймгийн Баянхайрхан сумын ажлын хэсгийн акт №2”-ыг, Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг шинээр гаргасан далд ажлын тухай Завхан аймгийн ажлын хэсгийн акт №3”, Тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн актын хамт үйлдэж хүлээлгэн өгнө,
- Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооног бүрт суурилуулна. Худгийн усны шахуурга дараах шаардлагыг хангасан байна. Үүнд Гарал үүслийн гэрчилгээтэй, үйддвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байх.

Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хариуг худгийн паспортод хавсаргасан байх.

Худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлийг худгийн ажил эхлэхээс өмнө аймгийн БОАЖГазраас авна. /аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 1 цооног өрөмдөх зөвшөөрөл 240 000 төгрөг Техникийн тодорхойлолт шаардлагад заасан хэсэг тус бүрээр саналаа тодорхой тайлбарын хамт, цооногийн хийц зохиомж, бүдүүвч, цооногийн гүн, суултын болон шүүр яндангийн голч зэрэг үзүүлэлтийг танилцуулгын хамт ирүүлнэ. Худгийн үзүүлэлт болон хөрөнгө


оруулалт, захиалагч гүйцэтгэгчийн мэдээллийг харуулсан гадна хаягийг холбогдох журмын дагуу хийж хадна.

ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
	Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага МИ8 6088:2010 стандартыг мөрдөнө.	
1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох	
1.1	Геофизикийн хайгуул судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногийг 219 мм-ээс багагүй голчтой өрөмдөх, бэхэлгээ, суултын болон шүүр янданг суулгана. Өрөмдлөгийн үед хурдас чулуулаг өөрчлөгдөх тутамд хөрсний дээжийг авна. Цохилтод өрмөөр өрөмдсөн, хадан хөрстэй цооногийн нийт гүнд суултын янданг заавал суурилуулна.	
1.3	Цооногийн ашиглалтын ундарга: 1.5 л/сек-ээс багагүй хүчин чадалтай байлгах.	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, 168мм-ээс багагүй голчтой янданг /Газрын гүний шаварлаг, нуралттай хөрсөнд заавал ган яндан суулгаж өгөх шаардлагатай/	
1-4	Шүүрийн яндан нь зориулалтын байх. материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, 168 мм-ээс багагүй голчтой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой 180 /хүйтний улиралд тэсвэртэй/ стандартын шаардлага хангасан байна	
Г.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	
1.8	Цооногт шавхалт хийх хугацаа: 24 цагаас багагүй, уст үеийн хүчин чадлыг тогтоох шавхалтыг шаталсан болон тогтмол ундаргатай <u>шявуялтаяр</u> хийнэ.	
1.9	Усны чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	
1.10	Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох, худгийн насос суурилуулан гагнах	

1.11	Дагалдах тоног төхөөрөмж /Хүчин чадал сайтай цахилгаан үүсгүүр, 4м.	
1.12	<ul style="list-style-type: none"> • Худгийн барилга нь 4х3м, ханын ендөр шалнаас дээш 2м] Материал: тоосго, блок, төмөр модон байж болно.1—Ханын зузаан: 38см-ээс багагүй гандан талыг фасатлаж, дотор талыг цагаан өнгөтэй гялгар хулсан хавтангаар доторлох, Худгийн дээр 30х30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ. • Худгийн цонх нь 40х50 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь Ус түгээх цооногын чанх харалдаа байрлана. • Усан сан нь босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м3 -ээс багагүй багтаамжтай, ган усан сан нь дээгүүрээ модон тагтай. Цэвэрлэгээ үйлчилгээг хийж доогуураа усаа шавхарах боломжтой. • Усны шахуурга болон цахилгаан үүсгүүрийг ашиглалтанд орсноос эхлэн 1 жилээс доошгүй баталгаат хугацаа өгнө. 1309001 гэрчилгээтэй байна. Албан ёсны үйлдвэрлэгчээс борлуулах эрхтэй компаниас худалдан авна. Баталгаат хугацаанд техникийн засвар үйлчилгээг бараа нийлүүлэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ. • Усны шахуурга нь усны орчны хасах 45 хэмээс нэмэх 35 хэм Нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон үйлдвэрлэгч компанийн хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар /Монгол хэл дээр/ бэлтгэсэн байна. • Усны шахуурга болон цахилгаан үүсгүүрийн түргэн элэгддэг эд ангийн сэлбэг тус бүр 2 ширхэгийг дагалдуулна. • Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно. • Худгийн усны тоолуур нь автомат байх шаардлагатай. Өвлийн хүйтэнд ард түмний ундны усны хэрэгцээг хангах тул мөстөлт үүсэхгүйгээр хэрэгцээг хангах боломжийг бий болгох. Мал услах талбай шаардлагагүй 	

2	Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах	
2.1	Худгийн ус шахуурга: 1809001:2015 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх, худгийн ундаргад тохируулан 1.5 КДУ-аас багагүй хүчин чадалтай, 3 салаа цахилгааны утастай, утас нь ус шахуургын удирдлагыг самбараар дамжин цахилгаанд холбогдоно. 2021 оноос хойш үйлдвэрлэгдсэн байна.	
2.2	Цахилгааны утас: Чанарын стандартын шаардлага хангасан 3 салаа, ус чийгнээс хамгаалагдсан давхар бүрээстэй, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2 м тутамд хавчиж /скоч, туузаар ороож болохгүй/ тогтооно.	
2.3	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, ус шахуурга ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах дохиололтой, насос ажиллуулах асаагууртай, саванд ус дүүрэхэд автоматоор ус гоожихгүйгээр хаагдах боломжтой байх хэрэгтэй.	
2.4	Бага оврын генератор: Бензин болон дизелээр ажилладаг /180 стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх 5.5КҮ-аас багагүй хүчин чадалтай байх	
3	Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
3.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/	
3.2	Худгийн насос, генераторыг ажиллуулах. үйлчилгээ хийх, заавар гарын авлага өгөх	
3.3	Худагт хаяг хадах, акт материалууд, техникийн паспорт бэлтгэн, хүлээлгэн өгнө.	



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГА *[Signature]* Х.ОЮУНЧИМЭГ

